

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР  
/МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Хэлэлцсэн асуудал</b>	<b>Хуудасны дугаар</b>
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-8
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-29
	1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн болон хамт үүргийн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2020.03.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	11-19
	2.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/	19-20
	3.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/	21-21
	4.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хууль тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	21-26
	5.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 13 гишүүн 2020.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	26-35
	6.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	35-39

**Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 22-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 27 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ш.Раднаасэд, Х.Нямбаатар;  
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Учрал.

**Нэг.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2020.03.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Л.Мөнхтүшиг, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Хонгорзул, Б.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

12 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаан дээр Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

**С.Бямбацогт:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гуравдугаар зүйлийн “мөн зүйлийн 10.6.22 дахь заалтын “виз” гэснийг “зөвшөөрөл” гэж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 4  
Бүгд 16  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 5 дугаар зүйлийн “10.6.14 дэх” гэснийг “10.6.22 дахь” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 1  
Бүгд 16  
93.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулын тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

**С.Бямбацогт:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтын 15.1 дэх хэсгийн “бүлэг жуулчдад” гэснийг “жуулчинд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 3  
Бүгд 16  
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл. Энэ хуулийг 2021 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэснийг хасах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 4  
Бүгд 16  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг үг хэлж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл** /Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Бямбацогт “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**С.Бямбацогт:** “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 4

Бүгд 17

76.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн дэмжсэн санал эсрэг гарсан тул дэмжсэнд тооцов.

*Уг асуудлыг 10 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл** /Монгол Улсын олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Бямбацогт Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**С.Бямбацогт:** “Монгол Улсын олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 3

Бүгд: 17

82.4 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Б.Хонгорзул, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэв.*

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Л.Мөнхбаатар нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

**С.Бямбацогт:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Авлигатай тэмцэх газрын даргыг Монгол Улсын Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж, зургаан жилийн хугацаагаар томилно.

21.2.Авлигатай тэмцэх газар дэд даргатай байна. Дэд даргыг Авлигатай тэмцэх газрын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж, зургаан жилийн хугацаагаар томилно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “даргыг” гэснийг “дарга, дэд даргыг” гэж, 21.5 дахь хэсгийн “даргын” гэснийг “дарга, дэд даргын” гэж, мөн хэсгийн “дарга” гэснийг “дарга, дэд дарга” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 8  
Бүгд 15  
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 3  
Бүгд 14  
78.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**С.Бямбацогт:** Дээрх санал хураалтыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 2  
Бүгд 14  
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсгийн “дарга” гэснийг “дарга, дэд дарга” гэж өөрчилж, мөн хэсгийн “21.1” гэснийг “21.1, 21.2” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 0  
Бүгд 14  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

**С.Бямбацогт:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 1  
Бүгд 15

93.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын гаргасан, “Энэ хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 4  
Бүгд 15

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

**С.Бямбацогт:** “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид буцаасугай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 2  
Бүгд 14

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 13 гишүүн 2020.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Хонгорзул, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Д.Ганбат, Ш.Адъяаа, С.Амарсайхан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ж.Сүхбаатар нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ш.Адьяа, С.Бямбацогт нар үг хэлэв.

**С.Бямбацогт:** Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 3  
Бүгд 14  
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.*

***Зургаа.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Д.Мөнхтуяа, Д.Эрдэнэбалсүрэн, Ц.Цогт, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монгол Улсын Их сургуулийн багш О.Мөнхсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Хонгорзул, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар Байнгын хорооны дарга С.Бямбацогт 3 өдрийн завсарлага өгөв. /11:15/

*Хуралдаан 1 цаг 48 минут үргэлжилж, 19 гишүүнээс 16 гишүүн ирж, 84.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 15 минутад өндөрлөв.*



**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

С.БЯМБАЦОГТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР  
/МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**С.Бямбацогт:** Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Ирцийг та бүхэндээ танилцуулъя. Бямбасүрэнгийн Амгалан гишүүн хүрэлцэн ирсэн байна, Цэдэвийн Сэргэлэн гишүүн, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн, Ширнэнбаньдын Адьшаа гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Бөхчуулганы Пүрэвдорж гишүүн, Норовын Алтанхуяг гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Баттөмөрын Энхбаяр гишүүн, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Цэндийн Мөнх-Оргил гишүүн, Хишгээгийн Нямбаатар гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн хүрэлцэн ирсэн байна. Раднаасэд гишүүн чөлөөтэй байгаа. Ингээд олонх хүрэлцэн ирсэн байна. Нийт гишүүдээс 15 гишүүн оролцож ирсэн байх шиг байгаа тийм үү? Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя. Өнөөдөр их олон асуудалтай байгаа. Бүтэн өдөржин оролдох байх.

1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн болон хамт үүргийн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг хийнэ.

2.Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. Хүний эрхийг хамгаалагч эрх зүйн байдлын тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

3.Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. Монгол улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн өөрөө хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллага хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн санал, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцаж санал, дүгнэлт боловсруулах үүрэг ажлын хэсэг байгуулна.

4.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэнэ. Засгийн газар 2020 оны 12 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг хийнэ.

5.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын хэсэг тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Улсын их хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 13 гишүүн өргөн мэдүүлсэн. Үүнийг тавдугаарт нь хэлэлцэнэ.

6.Монгол улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд гэсэн ийм зургаан асуудлыг хэлэлцүүлэхээр та бүхэндээ танилцуулж байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Тав.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулна.**

Төсөл санаачилсан илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр танилцуулна.

**Б.Энхбаяр:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр, Сүхбаатар, Мөнх-Оргил, Л.Энх-Амгалан, Ж.Бат-Эрдэнэ, Ундрам, Дамдинням, Ц.Мөнхцэцэг, Т.Доржханд, Жаргалмаа, Сандаг-Очир, Батжаргал, Ганболд нарын Улсын Их Хурлын 13 гишүүн Монгол Улсын Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн бариад байна.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сард Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан билээ. Энэ хүрээндээ шүүгчид хариуцлага тооцох, сахилгын хороог бие даан байгуулаад Шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр тодорхой өөрчлөлтүүдийг оруулсан. Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлаас тогтоол гаргаж 2020 онд багтаан Шүүхийн тухай хуульд хуулийг Үндсэн хуульд оруулсан үзэл баримтлалын хүрээнд шинэчлэн батлахыг чиглэл болгосон байгаа. 2019 оны 3 дугаар сард Монгол Улсын Их Хурлаас Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Прокурорын тухай хууль, Авлигын эсрэг өөр хуульд өөрчлөлт оруулаад шүүгч, прокурорын байгууллагын удирдлага, авлигатай тэмцэх байгууллагын удирдлагыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжөөр түдгэлзүүлэх, мөн огцруулах асуудлыг шийдвэрлэх ийм өөрчлөлтийг оруулсан билээ.

Энэхүү өөр өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулсан өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцэхгүй дараах нөхцөл байдал байгаа гэдэг утгаар дээрх өөрчлөлтүүдийг хүчингүй болгох хуулийн төслийг хууль санаачлагч санал болгож байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт ерөнхийлөгч тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгон олгож болно гэж заасан байгаа. Үндсэн хуульд Ерөнхийлөгч нь бүх шатны шүүгчийг томилох, чөлөөлөх шийдвэр гаргахаас бус тэдгээрийг томилох, чөлөөлөх саналыг өөрөө гаргах, тийнхүү санал, дүгнэлт гаргах, урьдчилсан урьдчилсан үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэгчийн хувиар оролцох бүрэн эрх байхгүй байна.

Хоёрдугаарт, 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах

шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно” гэж нэмэлт орсон билээ. Энэхүү нэмэлтийн дагуу бүх шатны шүүхийн шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах эрх хэмжээг үндсэн хуулиар гагцхүү Шүүхийн сахилгын хороонд олгосон байна. Өөрөөр хэлбэл, шүүгчийн эрх зүйн байдлын хуулиар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд энэ эрх хэмжээг олгосон нь хүчин төгөлдөр үндсэн хуульд нийцэхгүй байна.

Гуравдугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэж, мөн хуулийн 51 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хууль, Шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсвэл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно” гэж заасан байна. Шүүхийн тухай хуульд “шүүх нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас бие даасан байх бөгөөд шүүх эрх мэдлийг аливаа этгээд, байгууллага, этгээдээс хараат бусаар хэрэгжүүлнэ. Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт шүүхийн бие даасан байдлын зарчмыг алдагдуулсан, дордуулсан хууль тогтоомж болон захиргааны акт гаргахыг хориглоно” гэж заасан байна.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж нь хууль зүйн хүчин чадлын хувьд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан хууль, бусад шийдвэрээс доогуур эрэмбэлэгдэж зөвлөмжийн шинж чанарыг агуулна. Хууль зүйн хүчин чадалгүй зөвлөмжийг үндэслэн бүх шатны шүүгч, Монгол Улсын Ерөнхий прокурор, авлигатай тэмцэх байгууллагын удирдлагыг албан тушаалаас нь түдгэлзүүлж байгаа нь Үндсэн хуульд заасан хууль ёсны байх зарчмыг гажуудуулсан байна.

Тавдугаарт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.1, 3.4.3-т үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал орохоор заасан. Энэ хүрээнд Монгол Улсын иргэдийн шударгаар шүүлгэх Үндсэн хуульд заасан үндсэн эрх ноцтой зөрчигдөж, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал алдагдах нөхцөл байдал бий болсон гэж хууль санаачлагчид үзлээ.

Ийм учраас Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийг зөрчсөн зохицуулалтыг хүчингүй болгож, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Прокурорын тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал авсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Энхбаяр гишүүнд баярлалаа. Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачилсан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Амарсайхан гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

**Н.Алтанхуяг:** Би ер нь бол үзэл баримтлалыг дэмжиж байгаа. Үндсэн хуульд төсвийн өөрчлөлттэй холбоотой их олон хуулийг бид нар янзлах ёстой юм. Зүгээр, харин Энхбаяр гишүүн ээ, би дарааллыг нь ойлгохгүй байна. Эд нарыгаа ингээд түрүүлж хүчингүй болгох юм уу, одоо бид нарын нөгөө яриад байсан бусад салбар хуулиудаа батлаад тэгээд тэрэн дотор нь энэтэй холбогдож эд нар хүчингүй болох юм уу? Нэг ийм жижигхэн завсар гарчихгүй юм уу? Энийг эсэргүүцээд байгаа юм биш шүү дээ. Ингээд зөрөөд гарчихаж байгаа байхгүй юу. Ер нь одоо ингээд ам нээснээс би хэлэхэд бид нар энэ дээр маш их удаж, буруу

юм хийгээд байгаа юм шүү. Үндсэн хуулиас хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх хууль гээд уг нь батлагдах ёстой. Тэр чинь байхгүйгээс болоод бид нар ингээд нэг үзэмжээрээ яваад. Одоо за, хамаа алга, энэ эрхүүдийг хүчингүй болгочих. Тэгээд өнөөдөр асуудал үүсвэл ямар хуулиар шийдэх юм? Шүүхийн тухай хууль батлагдаагүй, энэ Авлигын хууль чинь ч одоо л яригдаж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр ийм хийдэл үүсэхгүй юу? Миний асуулт.

Ингэж их яарах хэрэг байгаа юм уу? Та нар хэдүүлээ ярьж байгаад л нөгөө хуулиудаа л гялс баталчих л даа. Тэгээд л хууль батлагдсантай холбоотойгоор, тэр, тэр. Ингэвэл надад хууль эрх зүйн хувьд их зөв болмоор юм шиг санагдаж байна. Та нар бод доо, надад бол тийм завсар үүсчихэж байгаа юм шиг.

**С.Бямбацогт:** Алтанхуяг гишүүн ээ, Улсын Их Хурлын тогтоол гарсан. Үндсэн хууль өнгөрсөн 2019 онд батлагдсан. 2019 онд батлагдсантай холбогдуулаад бас 2020 оны 1 сард Улсын Их Хурлын 02 дугаар тогтоол гараад, 02 дугаар тогтоол дотор 48 хуулийг Үндсэн хуульд нийцүүлж өөрчил гэсэн Улсын Их Хурлын тогтоол. Энэ 48 хуулийг Засгийн газар өргөн барих ёстой. Засгийн газар үндсэндээ 10 орчим, 6, 7 орчим хууль нь өргөн барьчхаад явж байгаа. Бид нар Их Хурлын тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль гээд хуулиудаа хэлэлцээд, ингээд батлаад явж байгаа л даа. Шүүхийн тухай хууль бас яг үүнд багтсан. Шүүхийн тухай хуулийг ч гэсэн одоо 2020 онд багтааж батлах ёстой. Энэ хүрээндээ ингээд хуулиуд уул нь бас жоохон системтэй явж байгаа.

Тэгээд саяын Энхбаяр гишүүний нарын 13 гишүүний санаачилсан хууль, энэ Авлигын хуультай зэрэгцүүлээд бид нар сая өмнө нь Авлигын хуульд өөрчлөлт оруулах хууль хэлэлцлээ шүү дээ. Энэ дээр бас Энхбаяр гишүүний хөндсөн заалт хөндөгдөж байгаа. Шүүхийн тухай хууль дээр Засгийн газар өргөн барьсан хууль дээр бас Үндэсний аюулгүй аюулгүй байдлын зөвлөмжөөр шүүгч, прокурор, авлигатай тэмцэх газрын удирдлагыг чөлөөлдөг түдгэлзүүлдэг энэ асуудлыг бас хассан ийм хууль өргөн баригдсан, хэлэлцээд явж байгаа. Тийм болохоор Энхбаяр гишүүний өргөн барьсан хуулийг хэлэлцэх эсэхийг нь шийдчихээд нийлүүлээд хэлэлцээд явчихъя гэж байгаа юм. Энхбаяр гишүүний өргөн барьсан хуульд Авлигатай тэмцэх газрын дарга, шүүгч, прокурор эдгээрийг түдгэлзүүлэх асуудал гурвуулаа орчихсон байгаа. Үүнийх нь Авлигын хуулиар Авлигатай тэмцэх газрын дарга нь хөндөгдчихсэн, Шүүхийн хуулиар шүүхийн шүүгчид хөндөгдсөн. Ийм учиртай юм.

**Н.Алтанхуяг:** Тайлбар хэрэггүй шүү дээ. Би гурван өгүүлбэр ойлгочихдог юм.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Ганбат гишүүн асуултаа асууя.

**Д.Ганбат:** За миний асуултад их олон үгээр хариулах байх. Тэгж найдаж байна. Ийм л байна л даа, энэ хуулийн үр дагавар гэж юм байна. Нэгэнт өмнө нь баталсан хуулиа та хэд маань олонх байсан, тийм ээ? 65-уулаа ч байсан байх. Тэгээд манай тухайн үеийн бүлэг бол маш их эсэргүүцэж байсан юм байна лээ. Гэтэл өнөөдөр хамгийн буруу юм ийм байлаа, шударга ёсыг тогтооно гээд ингээд эхэлж байна. Та нарын тэр үзээд хараад байгаа шударга ёс нь ямар байдгийг нь мэдэхгүй байна. Энэ чинь бас нэг үр дагавар гээд нэг юм байна аа гээд би хэлээд байгаа нь өмнө нь буруу байсан юм бол тухайн үедээ баталж байсан та нарын хууль, энэ буруу хуулиас чинь болоод золиос гэж золиослогдсон хүмүүс яах юм

бэ? Тухайн үед нь томилогдсон ч байдаг юм уу, тийм байдалд ажлаа явуулж байсан шүүгчдийн гаргасан шийдвэрүүд чинь яах юм бэ? Энийг эргэж харах ёстой юу?

Тэгээд тухайн үедээ хэн нэгний захиалгаар ч юм уу, энэ асуудлаа шийдээд явчихсан байдаг. Хэн нэг нь ашигтай, танай намд ашигтай ч юм уу, тийм шийдвэрээ гаргуулаад авчихсан байдаг. За, танай нам гэж бодохгүй байна аа би бас. Хэсэг бусаг хүмүүст ийм юм цаана нь явж байсан уу? Тэр тусмаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гурван гишүүний хоёр нь намын гишүүний намын гишүүнчлэлийн харьяалалтай. Тэр нь Ардын намын гишүүд байсан. Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд хоёр. Одоо энэ буруугаа бусдад нялзаах маягаар нөгөө л башир аргаа хэрэглээд, ингээд золиослогдсон хүмүүсээ тэр чигт нь хаяад ингээд явах юм уу, яах юм бэ?

Хэрэв зөв байсан бол энэ хуулиа зөвөөр нь байлга. Та нарын шударга ёс тухайн үедээ өөр байдаг, өнөөдөр өөр байдаг ийм байж одоо болмооргүй л байгаа юм л даа. Энийгээ тэгээд надад, ард түмэнд одоо юу гэж тайлбарлах юм бэ? Тэрийг чинь сонсчихмоор байна.

**С.Бямбацогт:** Хууль санаачлагч хариулъя. Хэн хариулах вэ? Сүхбаатар гишүүн хариулъя.

**Ж.Сүхбаатар:** Эрхэм гишүүн Ганбатын асуултад хариулъя. Түрүүн би Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дээр түрүүн тайлбарласан. Улс төрийн эрх зүйн хувьд бол бас шударга бусыг тогтоох ийм улс төрийн тэмцэл явсан. Энэ тодорхой зэрэг “ad hoc” гэдэг л дээ. Хууль зүйн нэг тодорхой зорилгоор тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор хийгдэж байгаа ажиллагааг бол “ad hoc” гээд нэг удаагийн түр арга хэмжээ гэж үздэг. Тэгэхээр тухайн үед үүссэн юм юу болсон юм бэ гэхээр тэрийг дефакто, бодит байдал дээр үнэхээр хууль хүчний байгууллагуудыг өөрийнхөө багаж зэвсэг болгож байсан. Тэр хонгил гэж яриад байсан. Энэ ард түмэн чинь бас, улс төрчид ганцхан яриагүй л дээ, хүлээн зөвшөөрсөн байхгүй юу, хонгил. Энд шүүх, хууль сахиулах байгууллагын тогтолцооны гадна нэг босс байна. Дотор талд нь түүнийг гүйцэтгэгч, одоо тэр хурган боссууд нь байна. Энэ тогтолцоог нураахын тулд одоо байгаа хууль эрх зүйн хүрээн дотроос тодорхой нэг түр хугацаанд зохицуулалт хийе гэдэг байдлаар ингээд хийдэг. Гэхдээ энэ нь нийтлэг журмаас бол тодорхой хэмжээгээр бас гажиж байгаа юм. Гэхдээ үүргээ биелүүлчихсэн.

Сая тэр хууль санаачлагч яах вэ, тэнд байгаа хуулийн орчинд энэ нь ингээд гажуудал үүсгээд үндсэн зарчмаасаа, тэр чинь гадуур зохицуулалт хийгдэж байгаа учраас энэ дээр сая үндэслэлээ хэлсэн. Гэхдээ шийдэгдсэн, шийдсэн алхмууд нь буруу байсан гэсэн үг биш. Бид нар буцаагаад энэ зүйл өөрчлөгдөхөөр, түрүүн Алтанхуяг гишүүний хэлдгээр буцаад хэвийн байдалдаа орж ирж байгаа юм. Өмнөх байсан хууль зүйн орчныхоо зохицуулалт дор орж ирж байгаа юм. Энийг чинь өөрөөр, одоо бусад оронд бол цэвэрлэгээ гэж яриад байгаа юм л даа. Бид бол харин тэгж яриагүй.

Одоо Шүүхийн хууль хийх гэж байна шүү дээ. Бид нар энэ ажил дуусчихаагүй. Энэ хуулийг өөрчилж дуусангуут залгаад, шүүхийн цоо шинэ концепцтой хууль гарах гэж байна. Энэний араас дараагийн хуулиуд нь гарна. Тэгээд дэс дараатай хийгдэж байгаа юм. Тэрнээс одоо ингээд дуусчихаар хуучиндаа ганцхан орчхож байгаа биш. Өмнөх эрх зүйн байдалд орсон ч гэсэн

бид нар цоо шинэ Шүүхийн хуулийн тэр үндэслэлүүд нь, шүүхийн хариуцлагыг маш чангатгасан, хяналтыг нь чангатгасан ийм хууль нь залгаатай, ингээд яг араас нь залгагдаад явж байгаа байхгүй юу.

Хэрвээ энийгээ зүгээр ингээд хүчингүй болгоод орхичих юм бол яг хуучин хэвэнд нь үлдээчих юм бол түрүүний Алтанхуяг гишүүний хэлдгээр хоосон үлдчихнэ. Буруу байсан юм.

**Б.Пүрэвдорж:** Нэгдүгээр хариултыг хууль санаачлагч.

**Ж.Сүхбаатар:** Би хууль санаачлагч л да. Тэгэхээр Ганбат гишүүн ч гэсэн, энд хажууд сууж байгаа Алтанхуяг гишүүнийг мэднэ. Энэ хонгилоор явсан хүн гээд байна шүү дээ, өөрийгөө байнга. Энд дуудаж оруулж ирээд намайг Ерөнхий сайд байхад Ерөнхийлөгч гэдэг хүн дуудаж ирээд шоронд яв, явахгүй бол ийм үүрэг даалгавар биелүүл гээд хэлж байсан, гэрч шүү дээ. Энэ Алтанхуяг гишүүн өөрөө гэрчээр ярьж байгаа шүү дээ. Одоо чи шоронд явна, чамайг шүүхээр явуулна. Энийг нураах ажиллагааг энэ юм чинь хийж байхад тус болсон байхгүй юу.

Тэгээд Алтанхуяг гишүүн өнөөдөр Их Хурлын гишүүн болчихоод сууж байна шүү дээ. Хэрвээ энэ ажиллагаа явагдаагүй байсан бол Алтанхуяг гишүүн Улсын Их Хурлын гишүүн болж дуу хоолой нь гарахгүй. Тэр шорондоо байна уу, шүүхдээ очоод тэндээ хатчих байсан байх л даа. Тэгэхээр ажил явж байгаа юм.

**С.Бямбацогт:** Ганбат гишүүн тодруулах юм уу? Ганбат гишүүн тодруулъя.

**Д.Ганбат:** Ерөнхийдөө энэ хариулж байгаа байдлаас нь бол юу ч ойлгосонгүй. За яах вэ, хариул хариулахын тулд хариулж байх шиг байна. Гэхдээ би бол бүгдийг нь мэдэж байгаа л даа. Гэхдээ энийг ярьж чадахгүй байх шиг байна. Түрүүнийхээ хуулиар та нар одоо баахан хүмүүсийг хуулиа гаргаад шоронд явуулчихсан тийм ээ, тухайн үед. Одоо одоо яах юм бэ? Яах вэ, манай Алтанхуяг дарга тэр хонгилоосоо гараад ирсэн юм байна л даа. Тэгээд тэр хуулийн хүчээрээ энэ Их Хуралд сууж байгаа юм байна тийм ээ? Их Хуралд суух ёстой улсууд нь бас явчихсан уу, үгүй юу? Тиймэрхүү маягаар нарийн шириин ч гэдэг юм уу, ил ярьж болохгүй юмнууд яваад байна уу, үгүй юу? Бид нарт одоо ард түмнээс нуух юу ч байхгүй шүү дээ. Лав л надад байхгүй. Танайхны ярьдгаар юу билээ, гар цэвэр, ямар юм нь цэвэр билээ, тэгж яриад байдаг. Тэгээд ер нь бол одоо шударга ёсыг тогтооно гэдэг нэрийн доор баахан буруу зүйл хийдгээ больсон дээр байх аа.

**С.Бямбацогт:** Санал хэллээ. Адьшаа гишүүн асуултаа асууя. Пүрэвдорж гишүүн ээ, асуулт асуух гэж байна. Хурал битгий үймүүл ээ.

**Ш.Адьшаа:** Та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Би Энхбаяр гишүүнээс асууна шүү. Сүхбаатараас асуухгүй. Энэ 13 гишүүний санаачилсан хуулийн төслийг би ер нь дэмжихгүй байгаа юм. Яагаад дэмжихгүй байгаа юм бэ гэхээр үл ойлгогдох асуудлууд байна. Энэ Энхбаяр дандаа Үндсэн хууль тайлбарладаг. Үндсэн хууль тэгж зөрчсөн, ингэж зөрчсөн гэж ярьдаг. Энэ Үндсэн хуулийг чинь зөрчсөн зөрчөөгүйг тайлбарладаг Үндсэн хуулийн цэцийн ажлыг л энэ Энхбаяр сүүлийн үед яриад байгаа юм, ерөөсөө. Үндсэн хууль зөрчсөн юм бол Үндэсний аюулгүй зөвлөлийнхөө гурван гишүүнийг тэр Үндсэн хуульд өг өө, Энхбаяр аа.

Хоёрдугаарт нь, Үндсэн хуулийн ямар, ямар заалтыг зөрчиж түрүүчийн парламент, энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжөөр ийм хууль гаргасан юм бэ? Энэний ямар, ямар үр дагавар өнөөдөр Монгол Улсын улс төрийн бөгөөд хүний эрх, хууль зүйн ямар үр дагаврыг бий болгов оо? Энэ үр дагаврыг хариуцах эзэн байна уу? Нэг дэх асуудал.

Хоёр дахь нь, одоо энэ хуулийг батална гэж 13 гишүүн өргөн барьсан байна. Гэтэл Шүүхийн тухай хууль, Авлигын тухай хууль, энэ хуулиудад чинь давхар энэ асуудлууд чинь явж байна. Тэгээд энд нэг ямар нэгэн улс төрийн акц хийх юм уу? Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө л нэг ийм асуудлыг гаргаад энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн Үндсэн хууль зөрчсөн гэдэг ийм юмыг л явуулах байх, ийм зорилготой л гэж үзэж байгаа юм.

Гурав дахь асуудал, ер нь Энхбаяр гишүүн Үндсэн хууль үнэхээр зөрчсөн юм бол тухайн үед бүгд энэ чинь танай 65 гишүүнтэй, Засгийн газартай байсан шүү дээ. Яагаад Үндсэн хууль тэр зөрчиж байхад ийм асуудалд дуугүй 48 цагийн дотор гараа өргөж баталсан юм бэ?

Дөрөв дэх асуудал, нэг удаагийн арга хэмжээ авч хууль батална гэж Сүхбаатарын гишүүн юу яриад байна аа? Акц хийнэ ч гэж. Үндсэн хууль, бусад хуульд чинь байхгүй шүү дээ. Нэг удаагийн арга хэмжээ гэдэг үгийг би ойлгохгүй байна. Энэ чухал арга хэмжээ болсон гэдэгт бүх хүн бол шударга ёсны төлөө, Монгол Улсынхаа энэ байгалийн баялагийн эзэн байхын төлөө олон чухал шийдвэрүүдийг гаргасан, хууль хүчний байгууллага улс төрийн тэр одоо бүлэглэлийн гээд яриад байгаа эрх ашигт нийцсэн энэ юмыг таслан зогсоохын төлөө гаргасан. Үүний үр дүн өнөөдөр байгаа шүү дээ.

Энийг яагаад нэг жилийн өмнө гаргачхаад, дараа нь нэг жилийн дараа, энийг одоо бүр Үндсэн хуулийн хэмжээнд зөрчил болсон мэтээр ингэж ярьж хэлж хууль өргөн тайлбарлаж байгааг Энхбаяр гишүүнээс би асууя.

**С.Бямбацогт:** Хууль санаачлагч Энхбаяр гишүүн. Нэлээн хэдэн асуулт асуулаа, хариулъя.

**Б.Энхбаяр:** Баярлалаа. Тэгээд манай Адьшаа гишүүн бол энэ хонгилыг их сайн мэднэ л дээ. Өөрөө ч бас орон шоронд орж гарч л байсан хүн байх. Ер нь энэ хуулиас давсан үзэмж, дүр зураг ямар байдаг юм бэ, хуулийн байгууллагууд ер нь даалгавраар чиглэлээр яадаг вэ гэдэг гэдгийг бол бас биеэрээ туулсан хүн байх гэж ингэж ойлгож байгаа юм. Тэр ч утгаараа бас Адьшаа гишүүнийхээ энэ ярьж байгаа санал бодол, зүйлд хүндэтгэлтэй хандаж байна.

Үнэхээр яагаад Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа юм бэ гэж байгаа юм. Үндсэн хууль бол Монголын ард түмний нийтийн бүтээл. Энэ Үндсэн хуулийн цэцийн есөн гишүүний өмч биш. Монгол Улсын Үндсэн хууль Монголын ард түмэн бид гэж эхэлдэг. Улсын Их Хурал хууль батлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд батлах учиртай. Энэ бол ард түмнийхээ өмнө хүлээсэн үүрэг. Тэр ч утгаараа бүх шатны шүүгчийг зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хуульд заасан үндэслэлээр огцруулна гэж байгаа юм. Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур огцруулж болохгүй ээ гэж байгаа юм. Хэрвээ огцруулдаг болоод байвал тэр шүүх эрх мэдэл чинь хэн нэгэн даргын өмч болчихно, хэн нэгэн даргын албат болчихно, хэн нэгэн даргын зарц болчихно.



Монголын ард түмний үйлчлэгч биш. Монгол Улсын Үндсэн хуулийн албат биш, зөвхөн Үндсэн хуулиас давсан даргын боол болчихно.

Тийм учраас ийм боломжийг хуулиар зөвшөөрөх аливаа санаархлыг, Үндсэн хууль дээр тангараг өргөсөн хууль тогтоогчид бид нам үл харгалзан зөвшөөрч болохгүй. Үүний эсрэг хатуу зогсох ёстой гэж ингэж ойлгож байгаа. Тийм учраас Адьшаа гишүүнийгээ бас энэ асуудлыг дэмжинэ байх аа гэж ингэж итгэж найдаж байна. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Асуултад тодорхой хариулт өгөөч ээ гэж байна. Нэмэлт асуух уу та? Адьшаа гишүүн 1 минут.

**Ш.Адьяшаа:** Энхбаяр гишүүн одоо тавьсан асуултад хариулмаар байна. Нэгэнт энэ хуулийн хуулийн төслийг санаачилсан юм бол. Зүгээр, ингээд л нэг тунхагийн шинж чанартай юм яриад л, дээр нь одоо Үндсэн хуулийг тайлбарлаад л ингээд өнгөрөөж байна. Үнэхээр энэ хууль баталснаар ямар үр дагавар гарсан юм бэ? Монгол улсын хууль, шүүхийн тогтолцоонд хүний эрх, эрх чөлөөнд ямар үйлс хийсэн юм бэ, үүний хариуцлагыг хэн хүлээх вэ тухай л би асуугаад байгаа шүү дээ. Тэгээд хариулж өгөхгүй байна. Одоо хариулах тийм шаардлагагүй ч юм уу, хариулах тийм зориг зүрхгүй ч байгаа юм уу. Тэгвэл хариулахгүй байгаа юмыг одоо би хариул гэж шаардаад яах вэ. Би нэгдсэн чуулган дээр би энэ талаар өөрийнхөө байр суурийг илэрхийлнэ.

**С.Бямбацогт:** Хариулт байхгүй юу? Амарсайхан гишүүн асуулт асууя.

**С.Амарсайхан:** Би товчхоор асууна аа. Ер нь зүгээр шүүгчийг огцруулах, чөлөөлөх албан тушаалаас нь түдгэлзүүлэх асуудлыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд олгосон нь өөрөө Үндсэн хуулийг зөрчсөн асуудал болж байгаа. Тэр дундаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ эрх, үүргийг сахилгын хрроонд олгосонтой холбоотой энэ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт орохоор хуулийн төсөл оруулж ирсэн асуудлыг дэмжиж байгаа.

Гэхдээ миний асуух гэж байсан гол асуудал бас давхцаад байна. Үйлчлэл нь яг хэзээнээс байх вэ гэсэн түрүүнд тайлбарлаад хэлчихсэн учраас дахиж нэг их айхтар тодруулаад айх зүйл алга.

**С.Бямбацогт:** Санал хэлчихлээ. Гишүүд хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж дууслаа. Одоо хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Адьшаа гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

**Н.Алтанхуяг:** Саналаа хэлье. Түрүүн асуулт асуучихсан юм. Би ер нь санааг нь ойлгоод л явж байгаа л даа. Бид нар тийм хүнд хэцүү юман дундуур л явж байгаа шүү дээ. Нэг хэсэг энэ улс орон бол эх, толгой нь мэдэгдэхээ байсан, хууль, дүрэм журам гэдэг юм бол алга болчихсон ийм л байсан юм. Энийг янзлах гээд Үндсэн хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулсан. Тэгэхдээ өнөөдрийн оруулж ирж байгаа энэ асуудлыг, энэ Энхбаяр гишүүн этика, марал гээд их чухал зүйлийг Их Хурал дээр их гоё ярьсан. Минийхээр бол их гоё, ойлгомжтой хэлсэн. Тэгэхээр би этикийн хувьд энэ хуулийг би этикийн хувьд ярьж байгаа юм.

Тэртэй тэргүй энэ Үндсэн хуульд орсон өөрчлөлтийн чинь дагуу бид нар Шүүхийн хуулиа яриад Авлигынхаа хуулийг яриад. Прокурорын хуулийг бол

яриагүй л дээ. Прокурорын хууль ганцхан өгүүлбэр байгаа юм чинь. Ингээд явж байхад энийг зэрэгцүүлж орж ирж байгаа нь надад ёс зүйн хувьд бол жаахан тийм буруу харагдаад байгаа юм даа. Уг нь нөгөө хуулиудаа яриад л, тэгээд л тэрний дагуу эд нар нь хүчингүй болж байсан бол болно. Бямбацогт даргын яриад байгаа шиг урт тогтоол гарсан гээд, надад битгий тийм юм тайлбарлая гэж би хэлж байна. Би тэрийг чинь ойлгож байгаа. Тэгээд ажлаа хий гээд байна. Ажлаа хийж байгаа дараалал чинь минийхээр бол буруу байна.

Өнөөдөр энийг хүчингүй болонгуут чинь тэр Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Их Хурлын даргаас энийг чинь авчихангуут ямар хууль хүчинтэй болох юм бэ?. Би ойлгохгүй байна. Сахилгын хороо чинь байхгүй. Энэ яах вэ, хэдхэн хоногийн асуудал л даа. Тэгэхдээ хэдхэн хоногийн асуудал ч гэсэн хууль чинь ингэж гардаггүй л байхгүй юу. Та нар одоо хуулийг надаас илүү сайн мэддэг байх. Би практик талаас нь хэлж байна. Тэгэхээр ийм хийдэл гарчих вий л гэж би санаа зовж та нарт хэлсэн юм. Тэгээд манай хууль Хууль зүйн байнгын хороохон үнэхээр энийгээ анхаарч үзээрэй.

Дахиад би нэг юм хэлье. Одоо хүнээс юм булааж авч байгаа юм шиг ийм юм хийдгээ боль оо. Би тэр үед Их Хуралд байгаагүй шүү. Монголын түүхэнд харахад Монгол Улс одоо хэдэн ч Ерөнхийлөгчтэй байна, Очирбат, Багабанди, Энхбаяр, Элбэгдорж, Баттулга гээд тав байгаа юм байна. Энэ таван нөхрөөс дөрвөн нөхөр бол дандаа Үндсэн хуулиар олгогдоогүй эрх мэдлүүдийг өөр дээрээ ёолкны мод шиг авч наасан. Одоо миний харж байгаагаар бол Баттулга гэдэг Ерөнхийлөгч Үндсэн хуульд өөрчлөлт оруулж байхад Үндсэн хуулийн тодорхой эрх мэдлүүдээс шүүх эрх мэдэл, бусад эрх мэдлүүдийг хараат бус болгох зорилгоор тодорхой эрх мэдлүүдийн татгалзсан юм байна лээ. Ийм Ерөнхийлөгч бас нэг удаа тохиосонд нь би бас баярлаж байгаа шүү. Та нар бас энэ юмыг шударгаар болж байгаа юмаа болж байна гэж хэлээд, болохгүй байгаа юма болохгүй байна гэж хэл. Тэгэхгүй хэдэн хулгайч нар ингээд л нэг эрх мэдэл авчихсан юм шиг, тэрнийг нь булааж авах гэж байгаа юм шиг байдлаар ийм хуулийн төсөл оруулаад байвал би бол этикийн хувьд ярьж байна шүү, ёс зүйн хувьд жаахан онцгүй шүү. Миний эрхэм гишүүд минь энийгээ анхаарч, тунгааж цаашаа юмаа хийгээрэй. Хийдэл гарчих вий. Яах вэ, Их Хурал дээр бид нар байгаа юм чинь, та нар хийдэл гаргах биш, шийдэх гэж оролдох байх.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Адьшаа гишүүн үгээ хэлье.

**Ш.Адьяа:** Энэ хууль Шүүхийн тухай хууль, Авлигын тухай хууль, бусад хуулиар энэ асуудлуудыг шийдэгдэх ийм асуудлууд яригдаад явж байхад Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын санаачилгаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрээр хуулийн байгууллагуудын удирдлагыг өөрчилсөн энэ асуудлыг хүчингүй болгох ийм хуулийн төслийг өргөн барьсан байгаа. Энд би их гайхаж байгаа юм. Нэг бол Монгол Ардын намын Ерөнхий сайд Хүрэлсүх, Их Хурлын дарга Занданшатар нартай хариуцлага тооцох ийм ажлын эхлэл юм уу? Нэг бол Монгол Ардын намын 65 гишүүн Үндсэн хууль зөрчсөн гэдгээ албан ёсоор Монголын ард түмэн зарлаж байгаа юм уу? Энэ хуулийн үйлчлэлийн дагуу Монгол Улс улсад шударга ёс, шударга шүүхэд итгэх итгэлийг авч ирсэн гэж яриад байгаа. Тэр олон асуудлыг цаашид харлуулах, энэ асуудлаар далимдуулж Монголын байгалийн баялгийг гадаадынханд олгодог, тэрэнтэй тэмцэх үйл ажиллагааг саармагжуулах ийм зорилгыг агуулж байгаа юм уу? Үгүй бол Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө улс төрийн шалтгаантай ийм шийдлийг гаргаж

байгаа юм уу гэдэг ийм бодлын үүднээс л би энийг харж байгаа юм. Тэрнээс биш энэ хууль зайлшгүй одоо шийдэх асуудал биш байсан. Энэ асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээр хэрэг маргаан үүсгэгдээд явж байгаа. Энхбаяр гишүүн энэнээс мэдэхийн дээдээр мэдэж байгаа.

Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд үндсэн хууль тайлбарлаж, нийгмийн сэтгэхүйд зориулж, тэр өөрийнхөө хийх гэж байгаа үйлдлийг зөв мэтээр явдаг энэ явдлаа бас цаашид анхаармаар байна. Өнөөдөр хууль, шүүх, шүүхэд итгэх итгэл, шударга ёсны асуудал, шударга шүүхээр шүүлгэх асуудал бол өнөөдөр Монголын нийгэмд хамгийн чухал асуудал байгаа. Ийм учраас энэ хуулийн төслөө Монгол Ардын намынхаа бүлэг дээр ярьж, бусад Авлигын эсрэг хууль, Шүүхийн хуультайгаа нийцүүлж нэг мөр оруулж ирвэл бас өнөөдөр нийгэмд харагдах байдлаараа ч, нөгөө талаасаа хуулийнхаа бодлогын хүрээнд ч гэсэн энэ зарчмын асуудал байх аа гэж бодож байгаа юм.

Шүүхийн хуулийг хэлэлцэх явцад Энхбаяр гишүүн хэлээд байгаа юм, бид хувьсгал хийнэ гэж ярьсан. Инээх юм байхгүй ээ, Энхбаяр аа. Энийг бол чи Шүүхийн зөвлөлийн аа ажлын хэсгийн анхны хурал дээр хэлсэн шүү дээ. Тэр хувьсгал чинь энүүгээр эхэлж байгаа юм уу? Энийг цаг хугацаа харуулна шүү, Энхбаяр аа. Ийм учраас тэр тухайн цаг үед Монголын шүүх, хуулийн байгууллага, улс төрийн нөхцөл байдал ямар байсныг бүгд мэдэж байгаа, мэдэж байгаа. Үүний үр дүн өнөөдөр гараад явж байгаа. Гэтэл энэ жоохон ч гэсэн үр дүн гаргаж, байгалийн баялагийг ард түмний мэдэлд байлгах, шүүх, хуулийн байгууллагын дампуурлыг засахын төлөө хийсэн энэ үйл ажиллагааг баллуурдах, цаашлаад буруутанг хайх ийм эхлэлийг тавьсан, ийм салхи салхилж байна гэж би бодож байгаа. Цаг хугацаа харуулна шүү дээ.

**С.Бямбацогт:** Адьшаа үг хэллээ. Би бас гишүүнийхээ хувьд хэдэн үг хэлчихье. Авлигын эсрэг хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль гээдэнэ гурван хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг сая 13 гишүүн 8 сарын 20-ны өдөр Засгийн газраас санал аваад, тэгээд 10 сард Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүсэлтээ өгсөн юм байна лээ.

Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга бол Үндсэн хуульд орсны дагуу өөрчлөлт хийгдэхээр 2020 оны 4 сард Их Хуралд Засгийн газраас өргөн баригдсан. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын хууль бол 2020 оны 12 сарын 1-нд өргөн баригдсан. Тэгээд энэ хуулийн төслүүдийн бас зарим зүйл заалт, зарим үзэл баримтлал нь ижилхэн байгаад байгаа учраас Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.24-т заасны дагуу нэг асуудлаар хоёр ба түүнээс дээш хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагч нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг анхны хэлэлцүүлгийн шатанд нэгтгэн нэг төсөл болгож Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар хэлэлцэнэ гэсэн заалт байгаа юм. Үүний дагуу нэгтгэж хэлэлцэх шаардлагатай болсон учраас хэлэлцэж байгаа юм. Бусдаар саяын ярьж байгаа Шүүхийн тухай хууль хэлэлцсэний дараа Авлигын эсрэг хууль хэлэлцээд эхэлсний дараа Энхбаяр гишүүн нарын гишүүд өргөн барьсан төсөл биш ээ. Энэ бол 8 сарын 20-ноос хойш яригдсан ийм төсөл явж байгаа юм. Ингээд бид нар хамтад нь хэлэлцээд явчихъя. Хамт нь хэлэлцэхгүй бол дараад нь дахиад тусад нь хэлэлцэх асуудал үүсэх гээд байсан учраас нэгтгэж хэлэлцэж байгаа. Энийг бас гишүүд ойлгоорой.

Тийм учраас одоо бид нар дэмжээд явчих нь зөв байх аа. Бүгдээрээ дэмжээд, хэлэлцэх эрхийг нь шийдчихье. Шийдсэнийхээ дараа бүгдээрээ хамтатгаад хэлэлцэхийг нь хэлэлцээд. Тэгэхгүй бол ганцхан Прокурорын хууль үлдчих гээд байгаа юм. Ийм асуудалтай юм шүү. Энийг гишүүдийгээ дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Гишүүд хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 78.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх талаар хэлэлцүүлгээ явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэн танилцуулах вэ? Саналаараа танилцуулах гишүүд байна уу? Мөнхбаатар гишүүн танилцуулчихъя.

Дараагийн асуудалд оръё. Одоо нэг том асуудалтай үлдсэн бусад нь гайгүй.

**Зургаа.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгээ явуулъя.**

Монгол Улсын Их Хурлын даргын 2020 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 32 дугаар захирамжаар байгуулагдсан хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр танилцуулна. Ажлын хэсэг наашаа суучхаарай.

**Б.Энхбаяр:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 10 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал болон холбогдох бусад хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2020 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 32 дугаар захирамжаар хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар

хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Адьшаа, Алтанхуяг, Мөнх-Оргил, Раднаасэд, Сандаг-Очир, Ж.Сүхбаатар болон холбогдох албан тушаалтнууд орж ажиллалаа.

Ажлын хэсэг өнгөрсөн хугацаанд нийтдээ зургаан удаагийн олон нийтийн хэлэлцүүлгийг хийсэн. Мөн шүүхийн байгууллагын нийт бүх шатны шүүхийн шүүгчдийн төлөөлөл болсон 150 гаруй шүүгчдийн хүрээнд хүртэл хэлэлцүүлэг хийж, холбогдох санал дүгнэлтийг авлаа. Мөн Парламентын судалгааны хүрээлэнгээр тодорхой захиалгат болон бие даасан, хараат бус эрдэмтэн судлаачдаар мөн тодорхой судалгаа шинжилгээний асуудлуудыг хийлгэж, холбогдох хуулийн төсөл боловсруулах санал дүгнэлтдээ ашигласан байна. Ажлын дэд хэсэг нийтдээ сүүлийн нэг сарын хугацаанд 21 удаа хуралдсан бөгөөд ажлын хэсэг 90-ээс дээш хувийн ирцтэйгээр нийтдээ найман удаа хуралдаж санал дүгнэлтээ гарган, зарчмын зөрүүтэй 75 саналыг бэлтгэлээ.

Ажлын хэсэг Шүүхийн тухай хуулийн төсөл дээр ажиллах хугацаандаа дараах үндсэн зарчмыг баримтлах нь зүйтэй гэж үзэж ажилласан. Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, түүний үзэл баримтлалыг хатуу чанд мөрдөх; хоёрдугаарт, Шүүхийн тухай хуулийг боловсруулахдаа судалгаа шинжилгээ, олон улсын дэвшилтэт чиг хандлагыг нутагшуулах; гуравдугаарт, одоо нэгэнт тогтсон буруу практикийг буюу хонгилогыг нураах; дөрөвдүгээрт, хэн ч шүүх эрх мэдлийн системд дураар халдах, хэн ч энэ системд дангаар дарга болж засаглах боломжгүй шударга ёсны процессыг биежүүлэх.

Дээрх дөрвөн зарчмаар дамжуулж дараах үндсэн дөрвөн үр дүнд хүрнэ гэж харж байна. Нэгдүгээрт, Монгол Улсын иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхээ хамгаалуулах үндсэн хуульд заасан үндсэн эрх баталгаажна; хоёрдугаарт, Монгол Улсын Үндсэн хуульд заасанчлан, бие даасан шүүх эрх мэдлийн хараат бус байдал, хангагдана; дөрөвдүгээрт, хамгийн шилэгдсэн буюу хамгийн сайн нь шүүгч болдог тогтолцоог бий болгоно. Шүүгчийн мэргэжлийн ба сахилгын хариуцлагын тогтолцоог жинхэнэ утгаар нь амилна гэж үзэж байгаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхнийг Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн ажлын хэсгийн санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Хэлэлцэж байгаа төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын дэд хэсгийг танилцуулъя. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Лхүндэвийн Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Дашдоржийн Мөнхтуяа, Улсын дээд шүүхийн шүүгч Дамдингийн Эрдэнэбалсүрэн, Улсын дээд шүүхийн шүүгч Цэндийн Цогт, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Барсүрэнгийн Баасандорж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Пүрэвжавын Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон, Монгол Улсын Их сургуулийн багш Одонхүүгийн Мөнхсайхан. Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна. Улсын Их Хурлын даргын зөвлөх Лүндээжанцан хүрэлцэн ирж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Ганбат гишүүн горимын саналтай гэсэн үү та? Ганбат гишүүнд микрофон өгье.

**Д.Ганбат:** Баярлалаа. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулаад гэж ярьж байгаа л даа. Нөгөө талаар Монгол Ардын намын бүлэг маань хоёр, гурван жилийн өмнө шударга ёс гээд л ярьж байсан. Тэгээд хоёр жилийн дараа ахиад л бас шударга ёс гээд л ярьж л байна л даа. Тэгээд энэ шударга ёс нь одоо харж байгаагаар бол яаж өөрчлөгддөг юм бэ? Тухайн цаг үеэсээ болдог юм уу, хоёр, гурван жилийн дараа өөрчлөгддөг юм уу гэсэн нэг юм байгаа. Тэгэхээр яг олон улсын стандартад нийцсэн, хүнлэг энэрэнгүй, ардчилсан нийгэм байгуулна гэдэгтэй нийцсэн тийм хуулийг батлаад, тийм шүүхтэй болмоор байгаа юм. Тэгэхээр энэ удаа одоо ийм шүүхтэй болно гэдэгт найдаж байна. Ингээд бас энэ ажлын хэсэг дээрээ нэлээн сайн ярилцах ёстой юм байна лээ гэж бид нар ойлгож байгаа. Долоо хэмжиж, нэг огтлох зүйл бол энэ шүүхийн тухай хууль. Ингээд олон удаа өөрчлөөд, солиод, хууль, хүчнийхээ байгууллагыг, шүүхээ, янз бүрээр өөрчлөөд байж болохгүй ээ. Тэгэхээр одоо энэ хуулийг бол ёстой долоо хэмжиж, нэг удаа огтлох, тэр стандартад нийцсэн тийм хууль гаргуулахын тулд ажлын хэсэг дээрээ ахиад сайн ярилцъя.

Иймд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлаар тав хоногийн завсарлага авч байна. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Ганбат гишүүн ээ, өнөөдөр 12 сарын 22-ны өдөр. Он дуусахад үндсэндээ нэг долоохон хоногийн хугацаа үлдэж байна. Тэгээд бид нар Монгол Улсын Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Түрүүн Алтанхуяг гишүүн хэлсэн тийм үү? Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ахлуулсан үндэсний зөвшил ажлын хэсэг байгуулаад, парламентад суудалтай бүх намууд нь оролцоод, гадна байгаа бүх намуудаа бас оролцуулаад иргэд, эрдэмтэн мэргэдийн судалгаа, судлаачдын саналыг аваад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бид нар хийсэн. 20-иод жил хийж чадаагүй Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ өөрчлөлтөд орсон гол нэг зохицуулалт бол яаж шүүхийг шударга болгох вэ, яаж шүүгчийг шударга болгох вэ, яаж шүүхийг хараат бус болгох уу гэдэг заалт орсон л доо.

Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сард 02 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолд 2020 хорин ондоо багтааж энэ Шүүхийн тухай хуулийг шинэчилж найруулж, баталгаа гэсэн үүргийг Улсын Их Хуралд өгсөн. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дагаж мөрдөх журмын тухай хуульд ч бас тодорхой зааж өгсөн. Тэгэхээр тодорхой хуулиар хугацаатай заагаад өгсөн асуудлыг бид нар тэр хугацаанд нь багтааж шийдэх ёстой. Тийм болохоор завсарлагын хугацааг жоохон богинохон авч болохгүй юу? 2020 оны 4 сард Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга өргөн баригдсан. 9 сараас хойш

үндсэндээ хэлэлцэж байгаа. Сая сүүлийн хоёр долоо хоног дараалан бас бид нар хойшлуулсан. Хангалттай танилцсан байх.

**Н.Алтанхуяг:** Бүлэг завсарлага авч байна.

**С.Бямбацогт:** Би бас эрхтэй Алтанхуяг гишүүн ээ. Шаардлагатай бол, хуульд заасан бол хугацааг богиносгож өгнө гэсэн хуралдаан даргалагчийн эрх байгаа. Би тэр эрхийнхээ дагуу ярьж байна. Олон юм битгий яриад бай Алтанхуяг гишүүн.

Тийм болохоор таныг би энэ хуулийн хугацааг бодооч ээ, завсарлагаа жоохон богиносгож болохгүй юу? Танай бүлгийн хурал дээр олон удаа Энхбаяр гишүүн ажлын хэсгээс орж асуултад хариулж саналаа хэлсэн шүү дээ. Завсарлагын хугацааг богиносгож болохгүй юу гэж хэлж байгаа юм, хуулийн хугацаандаа. Ганбат гишүүнд микрофон өгье.

**Д.Ганбат:** Бид бүхэн хуулийг сайн хэлэлцэж чанартай гаргах, хийдэл багатай байлгах ийм л үүрэгтэй улсууд л даа хууль тогтоогчид. энэ дотор 76 хууль тогтоогчоос 74 нь байх шиг байна тийм үү? Хоёр хүн байхгүй байгаа тийм ээ, тэр бол янз бүрийн шалтагтай байх. Энэ дээр би бас олон юм яриад баймааргүй байна. Таны ярьж байгаа юмнуудыг бас ойлгож байна. Тэгэхдээ хэдүүлээ ер нь дээр үеийн социалист уралдаан зарлаж байгаа юм шиг ингэж хуулийг төдөнд багтаана гэсэн энэ юм чинь бол болохгүй л дээ. Хамгийн гол нь сайн хэлэлцээд, сайн нягт нямбай ярилцаад хийдэлгүй хууль гаргах нь бид нарын тэргүүн зэргийн зорилт байх гэж бодож байна. Тийм зүйлийг ч гэсэн ард түмэн хүлээж байна. Тэгэхээр энийг бас та бодолц. Тэгээд дундын хувилбар гаргаад хэд хоногийн авсарлага авъя.

**С.Бямбацогт:** Чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 15.4-т шийдвэрлэх хугацаагаар хуралдаанаас завсарлага авах. Шийдвэрлэх хугацааг нь хуулиар тусгайлан заасан асуудлаар нам, эвслийн бүлэг завсарлага авах бол хуралдаан даргалагч завсарлагын хугацааг тухайн асуудлыг хуулиар тогтоосон хугацаанд шийдвэрлэх боломжтой байхаар тогтооно гэсэн байгаа юм. Хоёр хоногт болохгүй юу? За, гурван хоногийн завсарлага.

Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ